



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/08

Халбан

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.1.6 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр уурын зуухны тогоо нийлүүлэх ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбажав (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Ж.Пүрэвдорж (Дулааны инженер)

Д.Тодбаатар (Слесарь)


Ц.Лхагвасүрэн (Механик)

Нарийн бичгийн дарга: Д.Лхамсүрэн (Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан ажилтан)

2. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэж байгаа ажлуудыг ажлын даалгаварын дагуу гүйцэтгэсэн байдал, чанар, үр дүнг нягтлан шалгаж хүлээж авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР